



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2018 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 2/680

Өлгий

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", "г", Монгол Улсын Засгийн газрын 154 дүгээр тогтоол, Сангийн сайдын 239 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн 60 жилийн ой, Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль болон Улаанхус сумын Ерөнхий боловсролын 1,3 дугаар сургуулиудын ойн баярыг тохиолдуулан Аймгийн Засаг даргын Өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулан шагнасугай.

2.Шагналын нэр төрөл, хэмжээг хавсралтаар баталсугай.

3.Тус ойн баярын арга хэмжээний Өргөмжлөлийн үнэнд 191 мянган төгрөг, шагналд 900,0 мянган төгрөг багш, сурагчийн шагналын өргөмжлөлийн үнэд 16000 мянган төгрөг, нийт 991,0 (нэг сая ерэн нэгэн мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын тамгын газар (Х.Тилеген)-т зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Ербол)-т даалгасугай.



02910000